


Монгол Улсын экспортыг дэмжих бодлогын нөлөөллийн үнэлгээ

Д-р Ч.Нарантуяа (МУИС-ийн Эдийн засгийн тэнхим)


Б.Мөнх-Ирээдүй (Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн)

Д.Өнөржаргал (Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн)




Монгол Улсын Экспортын тойм


Нийт экспорт, тэрбум \$




Уул уурхайн болон уул уурхайн бус экспорт, %



Уул уурхайн бус экспорт, сая \$




- ☉ Нийт экспорт өсөх хандлагатай
- ☉ Экспортод эзлэх эрдэс бүтээгдэхүүн 2012 онд 91.9%, 2016 онд 86.4%
 - ☐ Үүнээс байгалийн чулуу, үнэт метал болон гоёл чимэглэлийг хасаж тооцвол уул уурхайн салбар ~75%
- ☉ Уул уурхайн бус экспорт өсөх хандлагатай




Уул уурхайн бус экспортын онцлог


Уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүн, %



Ялгаваргүй болон ялгавартай бүтээгдэхүүний хувийн жин, %




- ✦ Нэр бүхий 7 төрлийн бүтээгдэхүүн нийт экспортын 97.8% эзэлж байна
- ✦ Ялгавартай буюу өртөг илүү шингэсэн бүтээгдэхүүн уул уурхайн бус экспортын 7-10% (2007 онд өндөр хөгжилтэй орнуудад 63.2%, Латин Америк 21.7%)



Уул уурхайн бус экспортын чиглэл


	2010	2011	2012	2013	2014	2015	2016
БНХАУ	55.0	56.6	66.0	59.0	63.5	60.8	71.8
Европын Холбоо	23.4	23.6	20.0	25.7	21.7	15.2	14.9
<i>ХБНГУ</i>	5.8	3.5	4.5	3.9	2.5	1.9	6.5
<i>Итали</i>	8.5	12.2	9.0	11.1	8.9	7.6	5.0
<i>ИБУИНВУ</i>	6.1	4.1	3.4	5.2	3.3	2.7	1.5
Ази (БНХАУ-аас бусад)	9.7	10.7	7.6	7.1	7.3	15.0	8.9
<i>Япон</i>	0.7	1.0	1.5	2.3	2.0	2.2	2.1
<i>БНСУ</i>	0.7	0.9	1.5	0.8	0.9	9.5	1.2
ОХУ	8.1	6.5	2.7	2.3	1.6	2.5	1.3
Бусад	3.9	2.6	3.6	5.9	6.0	6.4	3.0
НИЙТ	100	100	100	100	100	100	100

- ✦ БНХАУ нийт экспортын 82-92% эзэлж байна (2010 оноос хойш)
- ✦ БНХАУ-ын уул уурхайн бус экспортын хувь 2010 оноос хойш огцом өссөн, Европын Холбоо болон ОХУ-ын хувь буурсан




Судалгааны аргачлал

- ❖ Экспортыг дэмжих бодлогын тойм
 - ❖ Байгууллагууд (институцийн тойм)
 - ❖ Бодлогын арга хэрэгсэл
- ❖ Экспортыг дэмжих бодлогын үр нөлөөг салбарын түвшинд судлах
- ❖ Уул уурхайн бус экспортод нөлөөлөх хүчин зүйлийг гравитацийн загварыг ашиглан үнэлэх




Экспортыг дэмжих бодлого

- ✦ Монгол Улс 1997 онд ДХБ-ын гишүүн болсон
 - ✦ Худалдааны чөлөөт (либерал) бодлого
- ✦ Экспортыг дэмжих анхны арга хэмжээ (ЗГ-ын тогтоол) 1998
 - ✦ Уул уурхайн экспортыг дэмжихэд чиглэсэн
- ✦ Экспортыг дэмжих үндэсний хөтөлбөр
 - ✦ 2013 – экспортыг дэмжих ерөнхий бодлого (эрдэс баялгийн бус экспортыг 2018 он гэхэд 3 дахин нэмэгдүүлж, нийт экспортын 21% хүргэх)
 - ✦ 2016 – экспортыг төрөлжүүлэх, инноваци, мэдлэгт суурилсан экспорт, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх (нийт экспортын 30%)
- ✦ 2013 оноос өмнө салангид арга хэмжээ, жижиг хөтөлбөр – илүү эрчимтэй бодлого шаардлагатай




Экспортыг дэмждэг байгууллагууд

- ✦ Төрийн байгууллагууд
 - ❖ 2013 оноос өмнө ХААХҮЯ, ҮХЯ, АҮЯ, ХөдЯ, ГХЯ зэрэг яамд, Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг, ЭСЯ-ууд
 - ❖ Экспортыг дэмжих арга хэмжээ (ЖДҮ сан г.м.)
- ✦ Олон нийтийн байгууллагууд
 - ❖ МҮХАҮТ, мэргэжлийн холбоод (Ноос ноолуур, Аялал жуулчлал, Арьс шир, Хүнсчид, ХАА хоршоологчид)
 - ❖ Хязгаарагдмал хүрээнд үйл ажиллагаа явуулдаг
- ✦ Олон улсын байгууллагууд
 - ❖ АХБ, ДБ, GIZ, USAID, SDC, JICA
 - ❖ Ихэнх нь шууд бус дэмжлэг, тодорхой асуудал эсвэл салбарт чиглэсэн
- ✦ *Decentralized public model* – зохицуулалт илүү шаардана, хамтын ажиллагаа илүү чухал, одоогийн байдлаар эдгээр нь сул байна
- ✦ Цаашид бодлого төвлөрөх хандлага ажиглагдах магадлалтай




Экспортыг дэмжих бодлогын арга хэрэгсэл

- ✦ Санхүүгийн болон санхүүгийн бус арга хэрэгсэл
- ✦ Санхүүгийн арга хэрэгсэл
 - ✦ Уламжлалт арга хэрэгсэл, Монголд давамгайлах шинжтэй
 - ✦ Экспортлогчдод зориулсан хөнгөлөлттэй зээл, мөнгөн төлбөр, хөрөнгө оруулалт, татварын хөнгөлөлт зэрэг
- ✦ Санхүүгийн бус арга хэрэгсэл
 - ✦ Төрийн үйлчилгээ (гааль, татвар, тусгай зөвшөөрөл, мэргэжлийн хяналт, тээвэр)
 - ✦ Төрийн бус үйлчилгээ (даатгал, мэдээлэл, сурталчилгаа, зуучлал, ложистик)
 - ✦ Ялангуяа ялгавартай бүтээгдэхүүн экспортлох үед мэдээллийн тэгш бус байдал хамгийн том бэрхшээл болдог




Экспортыг дэмжих бодлогын арга хэрэгсэл


- ❖ Экспортыг дэмжих санхүүгийн бус арга хэмжээ – бодлого
 - ❖ Үндэсний хөтөлбөр батлагдсан (цаашид өөрчлөлт орохоор хүлээгдэж буй)
 - ❖ Тээвэр зууч болон дэд бүтэц (Transit Mongolia хөтөлбөр, CAREC, etc.)
 - ❖ Чөлөөт худалдааны гэрээ (Япон)
- ❖ Экспортыг дэмжих санхүүгийн бус арга хэмжээ – үйлчилгээ
 - ❖ *Бизнес эрхлэхүй* зэрэг судалгаа – гадаад худалдааны саад өндөр
 - ❖ Экспортын нэг цэгийн үйлчилгээ нэвтрүүлэх – бүрэн шийдэгдээгүй
 - ❖ Сургалт – олон улсын байгууллагууд явуулдаг, хамрагдалт өндөр биш
 - ❖ ХАА-н бүтээгдэхүүний бирж – хязгаарагдмал хүрээнд, хүртээмж багатай байсан
 - ❖ Гадаадад компани, ТББ зэргийн төлөөлөл байхгүй
 - ❖ ЭСЯ-уудын эдийн засгийн чиг үүрэг сул хэвээр байна (зах зээлийн судалгаа, сурталчилгаа, зуучлал, мэдээлэл)



Уул уурхайн бус экспортын салбарууд

Уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын хэмжээ, сая \$






Худалдааны харьцангуй давуу тал

- ✦ Béla Balassa's "Revealed Comparative Advantage Index" (XRCA)

$$XRCA = \frac{X_{ij}}{\sum_i X_{ij}} \div \frac{\sum_i X_{iw}}{\sum_i \sum_w X_{iw}}$$

$$M = \begin{cases} 1 & \text{if } XRCA > 1 \\ 0 & \text{if } XRCA < 1 \end{cases}$$


- ✦ $M \geq 1$ байвал j орон i бүтээгдэхүүн дээр харьцангуй давуу талтай гэж үзнэ



Монгол улсын харьцангуй давуу тал

	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2016
Ноос ноолуур, сүлжмэл	2.20	2.25	1.77	1.20	1.32	1.57	1.33	1.38	1.29
Арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүн	3.01	2.73	1.89	1.76	1.13	1.24	0.93	1.03	0.91
Үндсэн төмөрлөг	0.11	0.13	0.10	0.07	0.07	0.08	0.12	0.23	0.28
Машин, тоног төхөөрөмж	0.04	0.04	0.02	0.01	0.02	0.05	0.05	0.04	0.08
Ургамалын гаралтай бүтээгдэхүүн	0.02	0.11	0.01	0.04	0.04	0.08	0.15	0.29	0.39
Малын гаралтай бүтээгдэхүүн	0.75	1.24	1.33	0.46	0.31	0.30	0.14	0.29	0.29
Хүнсний бэлэн бүтээгдэхүүн	0.05	0.09	0.07	0.06	0.07	0.11	0.06	0.10	0.07
Каучук, хуванцар бүтээгдэхүүн	0.02	0.01	0.01	0.01	0.01	0.02	0.01	0.01	0.03


- Монгол улс ноос, ноолуур, сүлжмэл эдлэл болон арьс шир, арьс ширэн бүтээгдэхүүн дээр харьцангуй давуу талтай байна



Салбаруудыг дэмжих бодлого

❖ 1. Ноос, ноолуур, нэхмэл бүтээгдэхүүн

- ❖ ЗГ-ын 11-р тогтоол (2011): Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам;
- ❖ ЗГ-ын 221-р тогтоол (2011): Ноолууран утас болон эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, ноос боловсруулах үндэсний үйлдвэрлэлийг бондын эх үүсвэрээс дэмжих (100 тэрбум ₮);
- ❖ ЗГ-ын 141-р тогтоол (2013):
 - Ноосон бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 45 сая долларыг 4.5 жилийн хүүтэйгээр Хөгжлийн банкаар олгох;
 - Оёмол бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 13.5 сая долларыг Хөгжлийн банкаар олгох;
 - Ноолууран бүтээгдэхүүний үйлдвэрлэлд 68.8 сая долларыг Хөгжлийн банкаар олгох;
- ❖ ЗГ-ын 87-р тогтоол (2014): Ноолуурын үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх журам (батлан даалт-100 тэрбум);
- ❖ ЗГ-ын 165-р тогтоол (2014): Ноолуурын салбарын үйлдвэрлэлд дэмжлэг олгох;
- ❖ ЗГ-ын 312-р тогтоол (2015): Оёмол бүтээгдэхүүн, хувцас үйлдвэрлэлийг дэмжих зээл олгох (нийт 13 төсөлд 300 тэрбум ₮);
- ❖ ЗГ-н 337-р тогтоол (2015): Экспортод гаргах арьс, шир болон ноос, ноолууран бүтээгдэхүүний НӨАТ-ыг “0” болгох;



Салбаруудыг дэмжих бодлого

❖ **2. Үндсэн төмөрлөг болон түүгээр хийсэн бүтээгдэхүүн**


- ❖ ЗГ-ын 312-р тогтоол (2015): Төмөрлөгийн үйлдвэрлэлд арилжааны банкнуудаар дамжуулан санхүүжилт олгох (300 тэрбум);
- ❖ Хөгжлийн банк:
 - Самурай бондоос 22.7 сая долларыг үйлдвэржилтийг дэмжих төсөлд зарцуулсан (Барилгын арматурын үйлдвэрийн төсөл);
 - Дархан, Сэлэнгийн бүсэд хар төмөрлөгийн цогцолборын дэд бүтцийн хамт байгуулах төсөл (700 сая доллар-Хэрэгжээгүй);

❖ **3. Машин, механик төхөөрөмж, эдгээрийн сэлбэг, эд анги**

- ❖ ЗГ-ын 315-р тогтоол (2015): Метал боловсруулалт, машин үйлдвэрлэлд арилжааны банкнуудаар дамжуулан санхүүжилт олгох (300 тэрбум);

❖ **4. Авто, агаарын ба усан замын тээврийн хэрэгсэл, эд анги:**


- ❖ ЗГ-ын 315-р тогтоол (2015): Метал боловсруулалт, машин үйлдвэрлэлд арилжааны банкнуудаар дамжуулан санхүүжилт олгох (300 тэрбум);



Салбаруудыг дэмжих бодлого

❖ **5. Арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл**

- ❖ ЗГ-ын 198-р тогтоол (2012): Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн, малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох;
- ❖ ЗГ-ын 356-р тогтоол (2014): Арьс, шир боловсруулах үйлдвэрийн байршлыг тодорхойлж, түүний дэд бүтэц, бохир усыг цэвэрлэх байгууламж байгуулах;
- ❖ ЗГ-ын 198-р тогтоол (2014): Арьс, ширийг гүн боловсруулах болон түүгээр эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн төсөлд зориулан арилжааны банкаар дамжуулах зээл олгох (30 тэрбум ₮);
- ❖ ЗГ-ын 337-р тогтоол (2015): Экспортод гаргах арьс, шир, ноос, ноолууран бүтээгдэхүүний НӨАТ-г "0" болгох;



Салбаруудыг дэмжих бодлого

❖ **6. Мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн**


- ❑ ЗГ-ын 141-р тогтоол (2013): Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд Хөгжлийн банкаар дамжуулан жилийн 4.5 хувийн хүүтэй 27.7 сая долларыг зээл олгох;
- ❑ ЗГ-ын 492-р тогтоол (2015): Мах хөтөлбөр (дотоодын хэрэгцээний махны нөөц 25 тэрбум ₮, экспортыг дэмжих 75 тэрбум ₮). Экспортыг дэмжих 75 тэрбум ₮-ийн санхүүжилт хийгдээгүй;

❖ **7. Хүнсний бэлэн бүтээгдэхүүн**

- ❑ Хүлэмжийн аж ахуй байгуулахад Хөгжлийн банкаар дамжуулан жилийн 4.5 хувийн хүүтэй 17.4 сая долларыг зээл олгох;


❖ **8. Ургамлын гаралтай бүтээгдэхүүн**

- ❑ Дэмжсэн төсөл, хөтөлбөр тодорхойгүй;




Уул уурхайн бус экспортын хэмжээ (сая \$)


Ноос, ноолуур, нэхмэл болон
нэхмэл бүтээгдэхүүн




Үндсэн төмөрлөг болон түүгээр
хийсэн бүтээгдэхүүн




Машин, механик төхөөрөмж,
сэлбэг, эд анги




Тээврийн хэрэгсэл, тэдгээрийн эд
анги






Уул уурхайн бус экспортын хэмжээ (сая \$)


Арьс, шир, ангийн үс, эдгээрээр хийсэн эдлэл




Мал, амьтан, тэдгээрийн гаралтай бүтээгдэхүүн




Хүнсний бэлэн бүтээгдэхүүн




Ургамлын гаралтай бүтээгдэхүүн





Экспортыг дэмжих бодлогын нөлөө

- ✦ 2011-2015 онд Засгийн газраас экспортын ихэнх салбарт дэмжлэг үзүүлсэн
 - ✦ Гол төлөв санхүүгийн дэмжлэг
 - ✦ Зарим салбарт аж үйлдвэрийг дэмжих ерөнхий арга хэмжээ мөн багтсан
- ✦ Зарим салбаруудад тодорхой өсөлт харагдаж байна –шалтгааныг илүү нарийн тодруулах
 - ✦ Арьс ширний үйлдвэр - зудын нөлөө?
- ✦ Зарим шууд дэмжлэг аваагүй салбарын экспорт өссөн
- ✦ Экспортыг дэмжих салбарын бодлогын үр дүн тодорхой бус
- ✦ Зөвхөн экспортыг онилсон бодлогын хэрэгцээ байна
- ✦ Салбар дэмжсэн санхүүгийн бодлогод улс төрийн нөлөө илүү их байх боломжтой – эзнээ олоогүй зээл г.м. – бодлогын үр өгөөжийг бууруулна



Уул уурхайн бус нийт экспортын шинжилгээ

- ✦ Гравитацийн загвар Anderson & Wincoop (2003) "Gravity with Gravitas: A Solution to the Border Puzzle"

$$\ln(\text{non_m_exp}_{it}) = \beta_0 + \beta_1 \ln(Y_t) + \beta_2 \ln(Y_{jt}) + \beta_3 \ln d_j + \beta_4 \text{pol}_{it} + \gamma_j + \gamma_t + \gamma_{jt} + \epsilon_j$$

Энд:

$\ln(Y_t)$ - Монгол Улсын ДНБ;


$\ln(Y_{jt})$ - Импортлогч улсын ДНБ;

$\ln(d_j)$ - Хоорондын зай;

pol_{it} - Бодлогын дамми;


γ_j - Хугацаанаас хамаардаггүй Монгол болон импортлогчдын онцлог шинж (хиллэдэг эсэх, далайд гарцгүй эсэх);

γ_t ба γ_{jt} - Хугацаанаас хамаардаг онцлог шинж (дэд бүтцийн хөгжил, бодит ханш, ХҮИ, импортын тариф, худалдааны нэг холбоонд харьяалагддаг эсэх)




Загварт ашигласан тоон өгөгдөл

- ❖ Экспортын бодлогын нөлөөг үнэлэхийн тулд:
 - ❖ Экспортыг дэмжсэн төсөл, хөтөлбөрүүдийн мэдээлэл
 - ❖ Монгол Улсын гааль болон гадаад худалдааны тоон мэдээлэл, тухайлбал салбарын экспорт;
 - ❖ Олон улсын байгууллагаас импортлогчдын талаарх тоон мэдээлэл, тухайлбал ОУВС, ДБ, АХБ;
 - ❖ Худалдааны тоон мэдээллийн интернет дата серверүүд, жишээ нь International Trade Centre
- ❖ Нийт 93 түнш орны хувьд 2010-2016 оны өгөгдөл




Загварын үнэлгээ: хүлээгдэж буй үр дүн

- ❖ Загварын урьдчилсан үр дүн (статистикийн хувьд ач холбогдолтой):
 - ❖ Импортлогч улсын ДНБ нь Монгол Улсын экспортод эерэгээр нөлөөлдөг
 - ❖ Монгол Улсын экспортыг дэмжсэн бодлогууд экспортод эерэг нөлөөтэй
 - ❖ Импортлогч улсын тарифын түвшин экспорттой сөрөг хамааралтай
 - ❖ Хил залгаа байх нь экспортыг нэмэгдүүлдэг
 - ❖ Далайд гарцгүй байх нь экспортыг бууруулдаг



Гравитацийн загварыг цаашид сайжруулах нь

- ✦ Тоон мэдээллийн хамрах хүрээг өргөтгөж, загварын үнэлгээний үр дүнг шалгах;
- ✦ Үнэлгээний үр дүнгээс хамаарч, загварыг өөрчлөх, өргөтгөж, Монгол Улсын экспортын урсгалыг тайлбарлах чадварыг нэмэгдүүлэх



Дүгнэлт

- ❖ Монгол улсын экспортын сектор төрөлжөөгүй байна
 - ❖ Уул уурхайн бус экспортод цөөн тооны бүтээгдэхүүн давамгайлж байна
 - ❖ Нийт экспорт худалдааны ганц түнш орноос хэт хамааралтай байна
 - ❖ Харьцангуй давуу талтай хоёрхон бүтээгдэхүүнтэй
- ❖ Экспортыг дэмжих бодлого төвлөрсөн бус хэлбэртэй
 - ❖ Олон яамд оролцдог – салбараар
 - ❖ ТББ, ОУ байгууллагуудын оролцоо асуудал эсвэл салбарт чиглэсэн – уялдаа холбоо сул
- ❖ Экспортыг дэмжих санхүүгийн хөшүүргүүд давамгайлдаг
 - ❖ Салбарт чиглэсэн экспортын бодлогын үр нөлөөг шууд тодорхойлох боломжгүй
- ❖ Экспортыг дэмжих санхүүгийн бус бодлогын түвшний арга хэмжээ хөдөлж эхэлж байна, харин экспортлогчдод чиглэсэн үйлчилгээ сул хэвээр байна
- ❖ Гравитацийн загвар – хүлээгдэж буй урьдчилсан үр гарсан, цаашид сайжруулах